



Агуулга	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
Хүснэгтийн товъёг	4
Зургийн товъёг	4
Дүрслэлийн товъёг	4
АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ, ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ,	5
АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	5
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	6
А.1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ОРЧИН НӨХЦӨЛ БҮРДСЭН БАЙНА УУ?	7
А.1.1. Орон нутгийн өмчийн газартай байгуулсан гэрээг бодит цаг хугацаанд нь үнэн зөв дүгнэж цаашид хэрэгжүүлэх бодлогыг тодорхой болгоогүйгээс алдагдлын хэмжээ өсөх нөхцөл бүрдсэн байна.	7
А.1.2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг оновчтой зохион байгуулж ажиллаагүй байна.	7
А.1.3. Халаалтын зуухны нүүрс зарцуулалтын норм нормативыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгох шаардлагатай байна.	8
А.2. БАТЛАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ ЗОРИЛТОТ ТҮВШНИЙГ БИЕЛҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА УУ?	9
А.2.1. Зорилтот түвшнийг эдийн засгийн үндэслэлтэй тооцоо судалгаанд үндэслэлгүй хийсвэр байдлаар төлөвлөснийг хянаж засварлалгүйгээр шууд баталсан байна.	9
А.2.2. Зорилтот түвшин буюу эдийн засгийн үзүүлэлтийн хэрэгжилтийг бодит цаг хугацаанд нь үнэлж шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.	10
А.2.3. Санхүүгийн зохистой орчин бүрэн хангагдсан боловч удирдлагын арга барил, хяналтгүй байдлаас алдагдал хүлээж байна.	11
Б.1. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ААТҮГ-УДАД АЖИЛЛАХ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ОНОВЧТОЙ БҮРДҮҮЛСЭН БАЙНА УУ?	16
Б.1.1. Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын эрхэлж буй үйл ажиллагаа, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн тоо, үйлдвэрийн газрын хүчин чадал зэрэг бодит нөхцөл байдлыг харгалзан орон тооны хязгаарыг шинэчлэх шаардлага үүссэн байна.	16
Б.1.2 Сумдын дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын ажиллагсдад батлагдсан ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь байхгүй байна.	18
Б.2. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ААТҮГ-УДЫН ХӨРӨНГИЙН НӨӨЦИЙГ ОНОВЧТОЙ БҮРДҮҮЛСЭН ҮҮ?	18
Б.2.1. Улс, орон нутаг, орон нутгийн хөгжлийн сангаас дулаан үйлдвэрлэгч ААТҮГ-удад хангалттай хэмжээний хөрөнгө оруулалт хийгдсэн байна.	18
Б.2.2. Үндсэн хөрөнгө бараа материалыг НББОУС-ыг мөрдөж ангиллын дагуу зөв бүртгэх нэгдсэн бодлого шаардлагатай байна.	21
Б.2.3. Үйлдвэрлэлд ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг НББОУС-ын дагуу үнэн зөв байгуулаагүй байна.	21
Б.2.4. Хөрөнгийн тооллогыг нэр төдий баримт бүрдүүлэх хэмжээнд хийх буруу хандлага хэвшсэн байна.	22
Б.3. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ААТҮГ-УУД САНХҮҮГИЙН НӨӨЦИЙГ ҮНЭН ЗӨВ БҮРТГЭЛ БАЙНА УУ?	23
Б.3.1 Анхан шатны баримтаас хөөн тооцоход 15.6 сая төгрөгийн борлуулалтын авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.	23
Б.3.2. Бүрдүүлсэн орлогыг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулаагүй байна.	24
Б.3.3 Нүүрс худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.	27
В.1 Байгууллагын дотоод хяналт үр дүнтэй байна уу?	28



В.1.1.Үйлдвэрийн газруудын удирдлагын үе шатны хяналт үр нөлөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа бүхэлдээ хяналтгүй байна.....	28
В.2. Аймаг орон нутгийн захиргаа болон бусад хяналт шалгалтын байгууллагаас хяналт тавьж ажилласан уу?	28
В.2.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хяналт үр нөлөөгүй, эрсдэлтэй асуудлыг хөндөөгүй байна.....	28
В.2.2 Санхүүгийн тайлангийн аудитаар дулаан үйлдвэрлэгчдийн санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй хяналт хийсэн боловч зөрчил гаргасан нэгж гаргасан алдаандаа дүгнэлт хийж засаж сайжруулах талаар санаачилга гаргаагүй байна.....	29
В.2.3 Илэрсэн зөрчлийг таслан зогсоох, цаашид давтан гаргахгүй байх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.	30



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АШБ	Анхан шатны баримт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗЗН	Засаг захиргааны нэгж
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГАА	Говь-Алтай аймаг
ГА	Гүйцэтгэлийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ЭМТ	Эрүүл мэндийн төв



Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Батлагдсан орон тооны хязгаар	6
Хүснэгт 2	Хэрэглэгчийн судалгаа	6
Хүснэгт 3	2019 онд байгуулсан гэрээний хэрэгжилтийн давтан тооцоолол	7
Хүснэгт 4	Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн зарим үзүүлэлт	8
Хүснэгт 5	Нүүрс зарцуулалтын түүвэр	9
Хүснэгт 6	Борлуулалтын орлогын судалгаа (сая.төгрөг)	10
Хүснэгт 7	2019 оны Зорилтот түвшний үнэлгээ	10
Хүснэгт 8	Үнэ тариф	12
Хүснэгт 9	Төвлөрсөн халаалт хэрэглэгчийн ерөнхий мэдээлэл	12
Хүснэгт 10	Харьцуулалт	13
Хүснэгт 11	Төлсөн татварын мэдээлэл	13
Хүснэгт 12	Сул зардал	13
Хүснэгт 13	Тарифын өсөлтөөс шалтгаалсан орлогын өсөлт 2022 он	14
Хүснэгт 14	Одоо баригдаж буй барилгууд ашиглалтад орсноор нэмэгдэх орлогын төсөөлөл	15
Хүснэгт 15	Орон сууц хөтөлбөр хэрэгжсэнээр нэмэгдэх орлогын төсөөлөл	15
Хүснэгт 16	Зуухны хүчин чадлыг нэмэгдүүлснээр орох орлогын төсөөлөл	15
Хүснэгт 17	Орон тоо	16
Хүснэгт 18	Илүүц бүтэц	17
Хүснэгт 19	Хөрөнгө оруулалт (сая.төгрөг)	19
Хүснэгт 20	Элэгдлийн зардал (сая.төгрөг)	22
Хүснэгт 21	Борлуулалтын орлогын гүйцэтгэл (сая.төгрөг)	23
Хүснэгт 22	Зарцуулалт (сая.төгрөг)	24
Хүснэгт 23	Сул зардал (сая.төгрөг)	25
Хүснэгт 24	Нүүрсний худалдан авалт(сая.төгрөг)	28
Хүснэгт 25	Илэрсэн зөрчлийн хураангуй (сая.төгрөг)	30
Хүснэгт 26	Өмнөх шийдвэрийн үлдэгдэл (сая.төгрөг)	31

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Солонго дулааны станцын барилга байгууламж	19
Зураг 2	Суурин дулаан ААТҮГ-ын барилга	19
Зураг 3	Эрдэнэ эрчим хүч ОАНААТҮГ-ын гадна байдал	20
Зураг 4	Дарив сумын эрчим хүч ААТҮГ-ын гадна зураг	20

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Төвлөрсөн халаалтад холбосон ЗЗН	11
Дүрслэл 2	Төвлөрсөн халаалтын шийдэл	11
Дүрслэл 3	Нөхцөл байдлын шинжилгээ	14
Дүрслэл 4	Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчтэй хийсэн худалдан авалтын хувь	26



АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ, ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн “Орон нутгийн өмчит дулааны станцуудын үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт”-т хийх аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.
Аудитын зорилт	Орон нутгийн өмчит дулааны станцуудын үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалтад аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: ✓ Дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэн ажилласан эсэх ✓ Хөрөнгө нөөцийг үр ашигтай удирдаж байгаа эсэх ✓ Үйл ажиллагаанд тавих хяналтын тогтолцоог үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 4 орон нутгийн өмчит ААТҮГ-ын үйл ажиллагаа, хийгдсэн хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэлийг үнэлж дүгнэсэн баримт материал, өмч эзэмшлийн гэрээ, түүнийг дүгнэсэн байдал, үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөө түүний хэрэгжилтийг төрийн захиргааны байгууллагаас үнэлж дүгнэсэн байдал, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалттай холбоотой баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ.
Аудитын хязгаарлалт	Дулаан үйлдвэрлэдэг ААТҮГ-удын 2018-2021 оны санхүүгийн баримт материалыг хамруулсан.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 300, 3000-3100 үндэслэн боловсруулсан Гүйцэтгэлийн аудитын журамд заасан арга зүйг ашиглан Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материал, судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг явцын хяналт тавьж стандартыг хангуулан, ахлах аудитор Б.Цэцэгмаа, аудитор Х.Билэгбаяр, Э.Сүнжидмаа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв. Аудитын төлөвлөлтийн шатны урьдчилсан судалгаа тооцооллыг 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны хооронд хийж, гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэл гүйцэтгэж, нэгтгэлийг 2021 оны 06 дугаар сарын 16-аас 2021 оны 06 дугаар сарын 18-нд хийж аудитын тайланг 2021 оны 06 дугаар сарын 28-ний өдөр баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.
Хүндрэл бэрхшээл	Ковид-19 цар тахлын улмаас аймгийн хэмжээнд улаан түвшинд шилжин хөл хорио тогтоогдсон, аудитын багийн гишүүн ковид-19-өөр өвчилсөн зэрэг давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон учир зөвхөн Эрдэнэ сумын эрчим хүч ОНӨААТҮГ, Солонго дулааны станц ААТҮГ-т биечлэн очиж ажилласан.



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолоор “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм”-ийг баталсан байна. Уг дүрэмд орон нутгийн өмчит ААТҮГ-ын даргын эрх үүрэг хариуцлагын хэмжээ, эд хөрөнгийн үүрэг хариуцлагын хэмжээ, үйлдвэрийн газрын орон тоо бүтэц, цалин тогтоолтыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгасан байна.

Эрчим хүчний тухай хуулийн 11.3.3¹-д заасны дагуу аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоолоор баталсан дулааны эрчим хүчийг айл өрх, аж ахуйн нэгж байгууллага, төсөвт байгууллагад борлуулах үнэ тарифыг мөрдөж ажилласан байна.

“Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм”-д орон нутгийн өмчит ААТҮГ-ын захирал нь аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа явуулахаар тусгасны дагуу 2020 онд Орон нутгийн өмчийн газар дулаан үйлдвэрлэгчид гэрээ байгуулан аймгийн Засаг даргаар батлуулан ажилласан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-дад доорх орон тооны хязгаарыг баталж өгсөн байна.

Хүснэгт №1. Батлагдсан орон тооны хязгаар

ҮЗҮҮЛЭЛТ/ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН НЭР	СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ	СУУРИН ДУЛААН	ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ	ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ
БАТАЛСАН ОРОН ТОО	25	14	12	14
ШИЙДВЭР ГАРГАГЧИЙН НЭР, ШИЙДВЭРИЙН ТӨРӨЛ	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол			
ОГНОО ДУГААР	2019.01.23 №04	2020.01.20 №06	2020.07.07 №50	2020.07.07 №51

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоолоос

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-уд нийт 442 цэгт төвлөрсөн халаалт өгч 150 цэгт улирлын шинж чанартайгаар хэрэглээний халуун ус өгч, 346 хэрэглэгчид цэвэр ус олгож, 120 үйлчлүүлэгчид халуун усны үйлчилгээ үзүүлж байна. Төвлөрсөн халаалт хэрэглэгчдийн 90 хувийг айл өрх, 5 хувийг төсөвт байгууллага 5 хувийг аж ахуйн нэгж байгууллага эзэлж байна.

Хүснэгт №2. Хэрэглэгчийн судалгаа

ҮЗҮҮЛЭЛТ/ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН НЭР	СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ	СУУРИН ДУЛААН	ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ	ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА	6	6	5	5
ААНБ	4	7	3	7
АЙЛ ӨРХ	368	22	0	10
ТӨВЛӨРСӨН ХАЛААЛТ ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО	378	35	8	20
ХЭРЭГЛЭЭНИЙ ХАЛУУН УС ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО	150	-	-	-
ЦЭВЭР УС ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО	-	-	156	190
ХАЛУУН УСААР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТОО	-	-		120

Эх сурвалж: Аудитын явцад хийгдсэн тооцоо судалгаанаас

¹ “Зохицуулах зөвлөлийн баталсан аргачлал, журмын дагуу харьяалах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тариф, хэрэглэгчийн үнийг батлах, шалгах, нийтлэх”



БҮЛЭГ А. ДЭВШҮҮЛСЭН ЗОРИЛТОО ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙНА УУ?

А.1. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ОРЧИН НӨХЦӨЛ БҮРДСЭН БАЙНА УУ?

А.1.1. Орон нутгийн өмчийн газартай байгуулсан гэрээг бодит цаг хугацаанд нь үнэн зөв дүгнэж цаашид хэрэгжүүлэх бодлогыг тодорхой болгоогүйгээс алдагдлын хэмжээ өсөх нөхцөл бүрдсэн байна.

Аудитаар дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 2018-2021 оны үйл ажиллагааг аудитад хамруулан үзсэн. Дээрх хугацаанд буюу 2018 онд орон нутгийн өмчид 2 ААТҮГ (“Дарив сумын эрчим хүч” ААТҮГ, “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ) үйл ажиллагаа явуулдаг байсан бол 2019 онд Есөнбулаг сумын шинэ суурьшлын бүсэд “Солонго дулааны станц” ААТҮГ, 2020 онд Жаргалан сумд “Суурин дулаан” ААТҮГ-ууд тус тус шинээр байгуулагдан ажилласан байна. 2018 онд үйл ажиллагаа явуулж байсан орон нутгийн өмчит ААТҮГ-удтай ямар нэгэн гэрээ хэлцэл байгуулж ажиллаагүй, 2019-2020 онд Орон нутгийн өмчийн газар (цаашид ОНӨГ гэх) дулаан үйлдвэрлэгч ААТҮГ-ын хооронд гэрээ байгуулан аймгийн засаг даргаар батлуулан ажилласан боловч 2019 оны байгуулсан гэрээг үнэн бодитой дүгнээгүй 2020 онд байгуулсан гэрээг 2021 оны 06 дугаар сарын 20-ны байдлаар дүгнээгүй, 2021 онд гэрээ байгуулаагүй байна.

Хүснэгт №3. 2019 онд байгуулсан гэрээний
хэрэгжилтийн давтан тооцоолол

ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН НЭР / ҮНЭЛГЭЭ	ОНӨГ-ЫН ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭ	АУДИТААР ДАВТАН ТООЦСОН ҮНЭЛГЭЭ
ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ	87%	69%
ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ	96.5%	78.5%
СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ	75%	61%

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ болон ОНӨГ-ын хооронд байгуулсан гэрээний биелэлтийг дүгнэсэн байдлыг аудитаар давтан тооцож үзэхэд бодит үнэлгээг 14-18 хувиар

өндөр үнэлсэн, огт хэрэгжээгүй асуудлыг хэрэгжсэнээр дүгнэсэн байна. Орон нутгийн өмчит ААТҮГ, ОНӨГ-ын хооронд байгуулсан гэрээг бодит цаг хугацаанд нь үнэн зөв дүгнэж тухайн жилийн алдаа, оноог хэлэлцэн цаашид хэрэгжүүлэх бодлогыг тодорхой болгоогүйгээс алдагдлын хэмжээ өсөх нөхцөл бүрдсэн байна.

Илрүүлэлт:

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын захиралтай байгуулсан гэрээг бодит цаг хугацаанд нь дүгнэж үр дүнг хэрэлцэж оновчтой шийдэл гаргаагүй байна.

А.1.2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг оновчтой зохион байгуулж ажиллаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.2² дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт 19-ний өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм"-ийн 11.4.3³ дахь заалтад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан батлуулж хэрэгжилтийг зохион байгуулах талаар тодорхой тусгасан байна. “Солонго дулааны станц” ААТҮГ-аас бусад нэгжүүдэд баталж мөрдөж байгаа НБББББ

² "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах"

³ "Тогтоосон журам заавар аргачлалын дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй болсон байна"



байхгүйгээс санхүүгийн ажил гүйлгээ нийтлэг эмх цэгцгүй, нэгдсэн бодлогогүй, үндсэн хөрөнгийн элэгдлийг харилцан адилгүй байгуулсан, анхан шатны бүртгэлээс хураангуй, дэлгэрэнгүй бүртгэл хөтлөлт дутуу, хангалтгүй байна. Техник технологийн эрин зуунд “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ, “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-уд нягтлан бодох бүртгэлийн программ хангамж ашигладаггүй атал гараар нягтлан бодох бүртгэлийн хураангуй, дэлгэрэнгүй бүртгэл хөтөлдөггүй, эд хариуцагчийн тайлан тооцоо гаргадаггүй байдал нь данс бүртгэл будилаантуулж бодит зарлагыг нэмэгдүүлсэн санаатай үйлдэл байна.

Аудитын явцад дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удад сангийн сайдын 2018 оны 100 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягт, хөтлөх аргачлал”-д тусгагдсан маягтын хэрэглээ бүртгэлийг үнэлэхэд дунджаар 61 хувьтай буюу бүртгэл хөтлөлт хангалтгүй дүн гарлаа. Онцгойлон “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ, “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-ын нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах шаардлага тулгарсан байна.

Хүснэгт №4. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн зарим үзүүлэлт

ҮЗҮҮЛЭЛТ/ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН НЭР	СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ	СУУРИН ДУЛААН	ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ	ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ
САНХҮҮГИЙН ПРОГРАММ ХАНГАМЖТАЙ ЮУ?	Тийм	Тийм	Үгүй	Үгүй
НБББББ-ТАЙ ЮУ?	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй
АШБ, ДЭЛГЭРЭНГҮЙ БҮРТГЭЛ, ЖУРНАЛ ХӨТЛӨЛТИЙН ХУВЬ	86%	69%	58%	30%

Эх сурвалж: Аудитын явцад хийгдсэн тооцоо судалгаанаас

Илрүүлэлт:

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг баталж мөрдөөгүйгээс санхүүгийн ажил гүйлгээ нийтлэг эмх цэгцгүй, нэгдсэн бодлогогүй, үндсэн хөрөнгийн элэгдлийг харилцан адилгүй байгуулсан, анхан шатны бүртгэлээс хураангуй, дэлгэрэнгүй бүртгэл хөтлөлт дутуу, хангалтгүй байна.

А.1.3. Халаалтын зуухны нүүрс зарцуулалтын норм нормативыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгох шаардлагатай байна.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удад 11 халаалтын зуух байгаагаас үйл ажиллагаандаа 8-ийг нь ашиглаж нөөцөд 3 зуух ашиглагдаагүй байна.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удад ашиглагдаж байгаа зуухны хүчин чадал ажиллах горим, норм нормативтай холбоотой албан ёсны тогтоол, шийдвэр дүгнэлт нэгж байгууллагуудад байхгүй байна. Удирдлагын зүгээс нүүрсний зарцуулалтыг зөвхөн баримжаа тооцоогоор хянаж иржээ. Зуухны нүүрс зарцуулалтын норм нормативыг мэргэжлийн байгууллагаар тогтоолгон баримталснаар нүүрсний зарцуулалтыг хянах цаашлаад хэмнэх бололцоотой юм.

Аудитаар нүүрсний хэрэглээнд түүвэр хийхэд “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ-ын халаалтын талбай 2019 оны 12 дугаар сард ЗДТГ шинэ байранд орсонтой холбоотой 4,498 м3-аар нэмэгдэж борлуулалтын орлого сард 6.2 сая төгрөгөөр өсөж нүүрсний зарцуулалт жилд дунджаар 56 тонн буюу 5.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-ын халаалтын талбай 2019 оны 11 дүгээр сард Сургуулийн өргөтгөл ашиглалтад орсноор 3,109 м3-аар нэмэгдэж борлуулалтын орлого сард 5.1 сая төгрөгөөр өсөж нүүрсний



зарцуулалт жилд дунджаар 263 тонн буюу 12.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. “Солонго дулааны станц” ААТҮГ нь аймгийн төвийн шинэ суурьшлын бүсэд байрладаг тул жил бүр хэрэглэгч болон халаалтын талбай нэмэгдсэн байна.

Хүснэгт №5. Нүүрс зарцуулалтын түүвэр

ААТҮГ-ын нэр	Солонго дулааны станц	Суурин дулаан	Эрдэнэ эрчим хүч	Дарив сумын Эрчим хүч
2018 он	-	-	657.9 тн	1,287.0 тн
2019 он	1,353.3 тн	-	680.6 тн	1,320.0 тн
2020 он	1,790.7 тн	595.3	713.5 тн	1,550.0 тн

Эх сурвалж: Аудитын явцад хийгдсэн тооцоо судалгаанаас

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-ууд үйлдвэрлэж буй дулааны эрчим хүчний хэмжээгээр тооцоо судалгаа хийж үйлдвэрлэлд гарч байгаа зардал, ашигт үйлийн коэффициентоор үйлдвэрийн газрын шийдвэрлэх тоон мэдээллийг бэлтгэх нь зүйтэй байна. Одоогоор зөвхөн халаалтын талбайн хэмжээнд тулгуурласан тоон мэдээллийг бүхий л үйл ажиллагаандаа хэрэглэж байгаа нь учир дутагдалтай байна.

Илрүүлэлт:

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад ашиглаж байгаа халаалтын зуухны нүүрс зарцуулалтын норм нормативыг баталж мөрдөөгүй байна.

А.2. БАТЛАГДСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ ЗОРИЛТОТ ТҮВШНИЙГ БИЕЛҮҮЛЖ АЖИЛЛАСАН БАЙНА УУ?

А.2.1. Зорилтот түвшнийг эдийн засгийн үндэслэлтэй тооцоо судалгаанд үндэслэлгүй хийсвэр байдлаар төлөвлөснийг хянаж засварлалгүйгээр шууд баталсан байна.

Зорилтот түвшин нь туйлын үнэн зөв байх зарчимгүй боловч хүрэх боломжит тоон үзүүлэлтийг бүрэн тусгасан байх ерөнхий шалгууртай. Дулаан үйлдвэрлэгч ААТҮГ-ын захиралтай байгуулсан гэрээ болон баталж өгсөн зорилтот түвшин нь тухайн байгууллагын хувьд заавал дагаж мөрдөх үйл ажиллагааны чухал баримт бичиг юм.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-ын захиралтай байгуулсан гэрээний 2.15⁴, 3.16⁵ дэх заалтад байгууллагын эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин баталж мөрдөх талаар тусгасан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшин нь нэгдүгээрт дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-д зорилтот түвшний төсөл боловсруулах хоёрдугаарт боловсруулсан төслөө ОНӨГ-т хүргүүлж хянуулах, гуравдугаарт аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, дөрөвдүгээрт аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн төслийг аймгийн ИТХ-д өргөн барьж батлуулах гэсэн процессоор эцэслэн батлагдсан байна.

Гэвч дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын төсөл бэлтгэсэн анхан шатны баримт материалд техник эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшнийг үзүүлэлт тус бүрээр

⁴ “ААТҮГ-ын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүрэх зорилтот түвшинг гэрээний хавсралтаар жил бүр баталж өгнө”

⁵ “Захирал нь үйлдвэрийн газрын зорилт, түүнийг хэрэгжүүлэх саналыг боловсруулж ОНӨГ-тай тохиролцсоны үндсэн дээр тухайн жилийн үйл ажиллагааны зорилтот түвшинг гэрээний хавсралтад заасан үзүүлэлтээр биелүүлэн үйлдвэрийн газрын ашиг орлогыг нэмэгдүүлэх үндсэн үүргийг хүлээнэ”



нарийвчлан тооцоолох маягт байгаа боловч санхүүгийн бодит үзүүлэлтийг харгалзаагүй байна. Тухайлбал:

Хүснэгт №6. Борлуулалтын орлогын судалгаа (сая.төг)

ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН НЭР/ ОН, ҮЗҮҮЛЭЛТ	БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО			
	2019 ОН		2020 ОН	
	ТӨЛӨВ ЛӨГӨӨ	ОРВОЛ ЗОХИХ ОРЛОГЫН ДҮН	ТӨЛӨВ ЛӨГӨӨ	ОРВОЛ ЗОХИХ ОРЛОГЫН ДҮН
ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ	169.3	193.2	219.9	198.2
ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ	243.6	256.7	184.8	276.8
СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ	439.9	355.6	592.2	509.4
СУУРИН ДУЛААН	-	-	237.9	232.7

Борлуулалтын орлогыг хэрэглэгчтэй байгуулсан гэрээ, бүртгэсэн авлагын мэдээлэлд үндэслэн давтан тооцоход “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ-ын орлогын төлөвлөгөөг 23.9 сая төгрөгөөр дутуу, “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-ын орлогын төлөвлөгөөг 13.1 сая төгрөгөөр дутуу, “Солонго дулааны станц” ААТҮГ-ын төлөвлөгөөг 84.4 сая төгрөгөөр илүү төлөвлөсөн байна.

Эх сурвалж: Батлагдсан зорилтот түвшин

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшнийг батлахдаа дараах санхүүгийн үзүүлэлтийг заавал тусгаж бодит хэрэгжилтийг тооцсоноор үйл ажиллагааны үр дүн сайжрахаар байна. Үүнд:

- ✓ Хэрэглэгчийн судалгаанд үндэслэсэн борлуулалтын орлого
- ✓ Нийт зардлаас НӨАТ-тэй худалдан авалт хийх зардлын дүн
- ✓ Барагдуулах богино хугацаат авлагын дүн
- ✓ Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлын дүн

Дээрх санхүүгийн наад захын үзүүлэлтэд бодит цаг үед нь хяналт тавиагүй, батлагдсан зорилтот түвшинд зардлыг хэт өндрөөр төлөвлөснөөс сул зардал гаргах нөхцөл бүрдэж орон нутгийн өмчит ААТҮГ-удын санхүүгийн зохистой харьцаа алдагдсан байна.

Илрүүлэлт:

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын зорилтот түвшин буюу үйлдвэр санхүүжилтийн төлөвлөгөөг батлахдаа бодит тоо судалгаа, байгууллагын санхүү, эдийн засгийн үзүүлэлтийг тулгуур болгоогүй байна.

A.2.2. Зорилтот түвшин буюу эдийн засгийн үзүүлэлтийн хэрэгжилтийг бодит цаг хугацаанд нь үнэлж шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-ын 2019 оны эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшин захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дараа оны II улиралд, 2020 оны эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшин захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг 2021 оны II улирлын байдлаар үнэлж дүгнээгүй байна.

Хүснэгт №7. 2019 оны Зорилтот түвшний үнэлгээ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН ОГНОО ДУГААР	ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ	ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ	СОЛОНГО СТАНЦ	ДУЛААНЫ
2020.05.29 №330			Хангалтгүй	
2020.05.29 №333	Бүрэн хангалттай			
2020.05.29 №334		Хангалттай		

Эх сурвалж: Аймгийн засаг даргын захирамж

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-ын эдийн засгийн үзүүлэлт зорилтот түвшин захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг тухайн ондоо багтаж дүгнэж цаашид




авч хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой зохион байгуулаагүйгээс тайлант оны эхний хагас жилийн гүйцэтгэл гарсан хойно буюу төлөвлөлт ухарч хийгдэж тухайн жилийн үр дүнг бууруулж байна.

А.2.3. Санхүүгийн зохистой орчин бүрэн хангагдсан боловч удирдлагын арга барил, хяналтгүй байдлаас алдагдал хүлээж байна.


Аудитын хүрээнд Баянхонгор, Баян-Өлгий, Завхан, Увс, Ховд аймаг өөрийн доторх засаг захиргааны нэгжүүдийн төвлөрсөн халаалтын асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлыг судаллаа.

Баянхонгор аймагт 1, Баян-Өлгий аймагт 3, Говь-Алтай аймагт 13, Завхан аймагт 2, Увс аймагт 0, Ховд аймагт 3 засаг захиргааны нэгжийн төвлөрсөн халаалтыг шийдвэрлээгүй байна. Судалгаанд хамрагдсан аймгуудаас манай аймгийн төвлөрсөн халаалттай засаг захиргааны нэгжийн тоо хамгийн бага буюу сумд тогодын 35 хувийн төвлөрсөн халаалтыг шийдвэрлэсэн байна. Бусад аймгуудын засаг захиргааны нэгжүүд 79-100 хувь төвлөрсөн халаалттай буюу нэг аймагт дунджаар 1-3 сум тосгон л төвлөрсөн халаалтгүй байна.

Дүрслэл №1. Төвлөрсөн халаалтад холбосон 33Н



Дүрслэл №2. Төвлөрсөн халаалтын шийдэл



Баянхонгор, Баян-Өлгий, Завхан, Увс аймгуудын төвлөрсөн халаалтыг 100 хувь хувийн хэвшил хариуцаж байна.

Ховд аймаг 2 сум, болон манай аймаг 3 сум аймгийн төвийн шинэ суурьшлын бүсийн төвлөрсөн халаалтыг төрийн болон орон нутгийн өмчит ААТҮГ хариуцаж байна.

Аймгуудад хувийн хэвшил төвлөрсөн халаалт хариуцахдаа ихэнхдээ хөрөнгө оруулалтын өртгөө нөхөх хүртлээ ашиглах нөхцөлтэй концессын гэрээгээр харилцаагаа шийдсэн байна.



Хүснэгт №8. Үнэ тариф

Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс тогтоосон үнэ тарифаас харахад манай аймгийн халаалтын хөлсний үнэ бусад аймгийн үнэ тарифаас харьцангуй өндөр ажээ. Мөн 2022 оноос Дарив, Эрдэнэ сумдын төвлөрсөн халаалтын үнэ тариф 150-200 төгрөгөөр нэмэгдэх шийдвэр гарсан байна.

Аймаг /Үнэ тариф	Тариф (Төгрөг)	
	Айл өрх	ҮААНБ
Баян-Өлгий	0	1210-1420
Баянхонгор	450	1100-1550
Говь-Алтай	400-800	1390-1750
Завхан	500	1100-1650
Увс	450-1000	950-1600
Ховд	400-800	1350

Эх сурвалж: ЭХЗЗ-ын тогтоол

Аудитаар Дарив, Жаргалан, Тайшир, Халиун Эрдэнэ сумдын төвлөрсөн халаалт хариуцдаг нэгжийн хэрэглэгчийн тоо, халаалтын талбай санхүүгийн үзүүлэлт адил төстэй буюу харьцуулж болохуйц байгаа тул 2020 онд гарсан санхүүгийн үзүүлэлтийг харьцуулан шинжилж дүгнэлт хийлээ.

Эдгээр сумдын дулаан үйлдвэрлэгчид 43 хэрэглэгчийн дулааны эрчим хүчээр хангаж байна. Хэрэглэгчийн төрөл, талбайн хэмжээ, үнэ тарифын ерөнхий мэдээллийг хүснэгт №9-д харуулав.

Хүснэгт №9. Төвлөрсөн халаалт хэрэглэгчийн ерөнхий мэдээлэл

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨРӨЛ	ЭРДЭНЭ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ ОНӨААТҮГ	ДАРИВ СУМЫН "ЭРЧИМ ХҮЧ" ААТҮГ	СУУРИН ДУЛААН ААТҮГ	ЗОСТ ӨНДӨР ХХК /ТАЙШИР СУМ/	ТЭРГҮҮЛЭН ХХК /ХАЛИУН СУМЫН ҮА/
ХЭРЭГЛЭГЧИЙН ТОО	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА	5.00	6.00	6.00	6.00	6.00
	ААНБ	3.00	7.00	7.00	3.00	3.00
ТАЛБАЙН ХЭМЖЭЭ	АЙЛ ӨРХ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА	-	10.00	22.00	13.00	5.00
	ААНБ	17,685.68	19,314.30	18,962.40	22,785.00	16,530.00
ҮНЭ ТАРИФ(ТӨГРӨГ)	ААНБ	709.00	532.90	910.00	545.00	514.00
	АЙЛ ӨРХ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА	-	242.30	1,107.00	717.00	321.50
	ААНБ	1,518.00	1,815.00	1,760.00	1,815.00	1,705.00
	ААНБ	1,518.00	1,815.00	1,210.00	1,815.00	1,210.00
	АЙЛ ӨРХ	-	880.00	550.00	660.00	550.00

Нүүрсний зарцуулалт нь халаалтын талбайн хэмжээ, халаалтын тогооны төрөл хүчин чадлаас хамаарч байгаа хэдий боловч харилцан адилгүй байна. Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит нэгжүүд хувийн хэвшлийн дулаан үйлдвэрлэгчдээс 137-192 тонн нүүрс илүү зарцуулснаар тайлагнасан байна. Орон тоо цалингийн зардлын хувьд Дарив, Тайшир сумд адил орон тоотой боловч орон нутгийн өмчит ААТҮГ-ын цалингийн зардал хувийн хэвшлийн цалингийн зардлаас 2.0 сая төгрөгөөр илүү гарсан байна. Татварын өмнөх ашиг алдагдлын тухайд хувийн хэвшил 5.3-18.8 сая төгрөгийн ашиг тайлагнасан байхад “Эрдэнэ эрчим хүч”



ОНӨААТҮГ 1.8 сая төгрөгийн ашиг бусад 2 нэгж 19-61.5 сая төгрөгийн алдагдал тайлагнажээ.
Хүснэгт №10-д тодорхой харуулав.

Хүснэгт №10. Харьцуулалт

ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН НЭР/ ҮЗҮҮЛЭЛТ	ХАЛААЖ БҮЙ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ	ЗАРЦУУЛСАН НҮҮРС /ТОНН/ ТОНН МӨНГӨН ДҮН		ОРОН ТОО	ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ	АШИГ АЛДАГДАЛ
ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ ОНӨААТҮГ	18,394.7	714	65.5	14	77.5	1.8
ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ ААТҮГ	20,089.5	1,082	-	14	80.5	(19.0)
СУУРИН ДУЛААН ААТҮГ	20,979.4	937	101.3	13	72.2	(61.5)
ЗОСТ ӨНДӨР ХХК /ТАЙШИР СУМ/	24,047.0	745	21.6	14	78.4	5.3
ТЭРГҮҮЛЭН ХХК /ХАЛИУН СУМЫН	17,365.5	800	140.0	9	39.5	18.8

Эх сурвалж: Аудитын явцад хийсэн судалгаа тооцоо

Төлсөн татварын төрөл дүнг гаргахад мөн л хувийн хэвшил улсад илүү татвар төлсөн байна.

Хүснэгт №11. Төлсөн татварын мэдээлэл

ТАТВАРЫН ТӨРӨЛ	ЭРДЭНЭ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ ОНӨААТҮГ	ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ ААТҮГ	СУУРИН ДУЛААН ААТҮГ	ЗОСТ ӨНДӨР ХХК /ТАЙШИР СУМ/	ТЭРГҮҮЛЭН ХХК /ХАЛИУН СУМЫН ҮА/
ААОАТ	-	3.8	0.3	0.7	1.9
Агаарын бохирдол	-	-	0.3	-	0.7
ҮХЭХАТ	0.0	-	-	0.0	0.4
НӨАТ	5.7	-	-	20.2	2.5
ЦХХТАО	4.5	-	3.6	4.2	3.3
Хог	-	-	0.1	-	0.3
Усны татвар	-	-	1.6	-	4.0
Дүн	10.2	3.8	5.7	25.1	13.1

Эх сурвалж: Үйлдвэрийн газруудын харилцахын хууль

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын алдагдлын гол шалтгаан нь хяналтгүй зарцуулалт төсвийн сахилга бат алдагдсан явдал байна. Тухайлбал:

“Дарив сумын эрчим хүч” ААТҮГ: Тус үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаа хангалтгүйгээс харилцахаар 2018-2020 онд зарцуулсан нийт 206.9 сая төгрөгийн зарцуулалт анхан шатны нотлох баримтаар дэмжигдэхгүй байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагдсан эсэх нь тодорхой бус байна. /Дэлгэрэнгүй тайлангийн Б.3.2 дахь хэсэгт бичигдсэн./

Хүснэгт №12. Сул зардал

“Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ-ын 2018-2020 оны санхүүгийн баримтыг хөөн шалгахад жилийн борлуулалтын орлогын 25- 37 хувийг хүснэгтэд дурьдсан сул зардалд хяналтгүй зарцуулсан байна.	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он
	Сул зардал	25%	37%	34%
	Орон тоо илүү ажиллуулсан	1%	0%	1%
	Хандив тусламж актын төлбөрт Нэрийн дансаар гарсан зарлага /Хамааралтай/	2%	1%	0%
	Эд хариуцагчийн тайланд орлогоор бүртгээгүй зардал	6%	32%	25%
		15%	3%	9%



Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит нэгжүүдийн өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ:

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын нөхцөл байдлын шинжилгээг нэгтгэн давуу тал, сул тал, боломж, аюул эрсдэлийг тодорхойлоход дараах байдалтай байна.

Дүрслэл №3. Нөхцөл байдлын шинжилгээ

ДАВУУ ТАЛ 1. Өрсөлдөгчгүй 2. Нэмэлт орлого олох боломжтой 3. Үйл ажиллагаа тогмолжсон 4. Төрөөс бодлогоор дэмжиж байна.	СУЛ ТАЛ 1. Халаалтын зуухны хүчин чадал ханасан 2. Орон тооны хуваарилалт оновчгүй 3. НББББББ байхгүй, санхүүгийн программ хангамж ашигладаггүй байдал 4. Хөрөнгө оруулалт чанаргүй хийгдсэн
БОЛОМЖ 1. Халаалтын талбай жил бүр нэмэгдэж байна. 2. 2022 оноос "Дарив сумын эрчим хүч" ААТҮГ, "Эрдэнэ эрчим хүч" ОНӨААТҮГ-т үнэ тариф 150-200 төгрөгөөр нэмэгдэж байна. 3. Үе шатны хяналтыг үр дүнтэй тавьснаар сул зардлыг багасгах боломжтой 4. Зуух нэмсэн тохиолдолд хэрэглэгч нэмэгдэх боломжтой /Зөвхөн "Эрдэнэ эрчим хүч" ОНӨААТҮГ-т/	АЮУЛ 1. Удирдлага ашиглал шамшигдал хийсэн байх 2. Зардлыг зөв удирдаагүйгээс өрийн дарамтанд орох 3. Хяналтгүй 4. Халаалтын зууханд урсгал засвар хийхгүй бол үйл ажиллагаа доголдох /"Дарив сумын эрчим хүч" ААТҮГ, "Эрдэнэ эрчим хүч" ОНӨААТҮГ-т/

Цаашдын боломж шийдэл:

1. "Эрдэнэ эрчим хүч" ОНӨААТҮГ, "Дарив сумын эрчим хүч" ААТҮГ-ын халаалтын үйлчилгээний төлбөр 150-200 төгрөгөөр өссөн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн шийдвэр гарсан байна. Одоогийн хэрэглэгчийн тоо талбайн хэмжээнээс тооцоход жилийн борлуулалтын орлого 35.7-52.1 сая төгрөгөөр өсөхөөр байна.

Хүснэгт № 13. Тарифын өсөлтөөс шалтгаалсан орлогын өсөлт 2022 он (сая төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ ОНӨААТҮГ	ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ ААТҮГ
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ (САЯ.ТӨГ)	232.50	287.30
ӨМНӨХ ОНООС НЭМЭГДЭХ ОРЛОГЫН ХЭМЖЭЭ (САЯ. ТӨГ)	52.10	35.70

2. "Солонго" хороололд аймгийн онцгой байдлын газарт халаалтын шугам очсон холбоход бэлэн, Музей, 320 хүүхдийн цэцэрлэг, хүүхэд залуучуудын хөгжлийн төв 150 айлын 2 блок орон сууц, Жаргалан сумд сургуулийн дотуур байрны барилга тус тус баригдаж байна. Жаргалан сумын "Суурин дулаан" ААТҮГ, "Солонго дулааны станц" ААТҮГ нь одоогийн хүчин чадлаа хөрөнгө оруулалт хийж нэмэгдүүлэхгүйгээр халаах боломжтой байгаа тул эдгээр газрын халаалтын талбайн хэмжээгээд борлуулалтын орлого нэмэгдэх боломжтой байна. Боломжит борлуулалтын орлогын төлөөллийг хүснэгтээр харууллаа.



Хүснэгт №14. Одоо баригдаж буй барилгууд ашиглалтад орсноор нэмэгдэх орлогын төсөөлөл

ҮЗҮҮЛЭЛТ	СУУРИН ДУЛААН ААТҮГ	СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ ААТҮГ
НЭМЭГДЭХ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ДУНДАЖ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ	5,000.00	19,183.00
НЭМЭГДЭХ АЙЛ ӨРХИЙН ДУНДАЖ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ		5,124.00
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ (САЯ ТӨГРӨГ)	64.00	281.40

3. Орон сууц хөтөлбөр хэрэгжүүлэхээр иргэдээс санал авахад Эрдэнэ сумд 67 өрх, Жаргалан сумд 66 өрх, Солонго хороололд 291 өрх хөтөлбөрт хамрагдах хүсэлт өгсөн байна. Тус судалгаанд үндэслэн борлуулалтын орлого нэмэгдэх төсөөллийг хүснэгтээр харууллаа.

Хүснэгт № 15 Орон сууц хөтөлбөр хэрэгжсэнээр нэмэгдэх орлогын төсөөлөл

ҮЗҮҮЛЭЛТ	ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ ОНӨААТҮГ	СУУРИН ДУЛААН ААТҮГ	СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ ААТҮГ
НЭМЭГДЭХ АЙЛ ӨРХИЙН ДУНДАЖ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ	2649.07	2772	12222
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ (САЯ ТӨГРӨГ)	10.60	11.10	48.90

4. “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ-ын зуухны хүчин чадлыг нэмэгдүүлснээр ЭМТ-ын байрыг халаах боломжтой байна.

Хүснэгт № 16. Зуухны хүчин чадлыг нэмэгдүүлснээр орох орлогын төсөөлөл

ҮЗҮҮЛЭЛТ	ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ ОНӨААТҮГ
НЭМЭГДЭХ АЙЛ ӨРХИЙН ДУНДАЖ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ	1,660.00
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ (САЯ ТӨГРӨГ)	24.80

Дулаан үйлдвэрлэгчдийн нийгэмд үзүүлж буй үр нөлөө:

Хурдацтай хөгжиж байгаа өнөө үед нийслэл хотын төвлөрлийг сааруулах хот хөдөөгийн ялгааг арилгах бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын суурь нь хүн амын төвлөрлийг сааруулах хөдөөд хөгжил, ая тухтай байдал бий болгох юм.

“Солонго дулааны станц” ААТҮГ-ын тухайд аймгийн төвийн шинэ суурьшлын бүсийг төвлөрсөн халаалтаар хангадаг. Одоогоор тус үйлдвэрийн газраас дараах байршлын айл өрх, албан байгууллага дэлгүүр хоршоо төвлөрсөн халаалт авч байна. Үүнд:

- ✓ Төсөвт Байгууллагын тоо - 8
- ✓ ААНБ-ын тоо - 4
- ✓ Төвлөрсөн халаалттай, халуун устай өрхийн тоо /солонго хороолол/-150
- ✓ Хөгжил хороолол 7.8.9.10 дүгээр хороолол-148
- ✓ Жинст багийн Жаргалант апартмент-50
- ✓ Дэвшил хороолол 11-р байр-20

“Солонго дулааны станц” ААТҮГ нь 368 айл өрхөд төвлөрсөн халаалт 150 айл өрхөд халуун ус, 12 албан байгууллагын 429 ажилтан албан хаагч, 1126 СӨБ, ЕБС-ын суралцагч, тэдгээрээр үйлчлүүлэгчдийг төвлөрсөн халаалтаар хангаж хүн амын ая тухтай байдалд үнэтэй хувь нэмэр оруулж байна.



Сумдын дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд нь тухай нутаг дэвсгэрийн хүн амын 5-12 хувийн амьдралын орчинд (гэр, ажлын байр) ая тухтай байдлыг бий болгож байна. Сумдад хүн амын дийлэнх хувь нь нүүдлийн мал аж ахуйн эрхлэн тархан байршдаг ба сумын төвд суурьшмал амьдралаар амьдардаг өрхийн 9-19 хувь нь орон сууцанд амьдарч байна. Жаргалан сумд орон сууцанд амьдардаг өрхийн 53 хувь, Дарив сумд орон сууцанд амьдардаг өрхийн 10 хувь нь төвлөрсөн халаалтад холбогдсон байна.

“Суурин дулаан” ААТҮГ нь Жаргалан сумын төсөвт байгууллагуудад 100 хувь ААНБ дэлгүүр хоршоодын 36 хувийг халаалтаар хангаж байна.

“Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ нь Эрдэнэ сумын төсөвт байгууллагуудын 67 хувь ААНБ, дэлгүүр хоршооны 4 хувийг халаалтаар хангаж байна.

“Дарив сумын эрчим хүч” ААТҮГ нь Дарив сумын төсөвт байгууллагуудад 100 хувь ААНБ дэлгүүр хоршооны 46 хувийг халаалтаар хангаж байна.

Албан байгууллага, дэлгүүр хоршоонд халаалт өгснөөр тус газруудын ажиллагсад, үйлчлүүлэгчид, СӨБ, ЕБС-д хамрагдагчдад ая тухтай байдлыг бий болгож нийгэмд эерэг үр нөлөө үзүүлж байгаа хэрэг юм.

Аудитын явцад дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-ын хэрэглэгчдээс санал асуулга авахаар google form ашиглан цахимаар хэд хэдэн удаа нийгмийн сүлжээнд байршуулсан боловч иргэдийн оролцоо хангалтгүй байлаа. Гэхдээ иргэдээс ирсэн тухайн сумын нүүрсний үнэ, халаалт эхэлдэг, зогсдог хугацаа дулаан үйлдвэрлэгчдийн тайлагнасан байдалтай тохирч байлаа.

Б.1. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ААТҮГ-УДАД АЖИЛЛАХ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ОНОВЧТОЙ БҮРДҮҮЛСЭН БАЙНА УУ?

Б.1.1. Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын эрхэлж буй үйл ажиллагаа, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн тоо, үйлдвэрийн газрын хүчин чадал зэрэг бодит нөхцөл байдлыг харгалзан орон тооны хязгаарыг шинэчлэх шаардлага үүссэн байна.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын орон тооны хязгаарыг батлахдаа үйлдвэрийн газрын саналыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсний үндсэн дээр аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулжээ.

Хүснэгт №17. Орон тоо

ААТҮГ-ын нэр	Солонго дулааны станц	Суурин дулаан	Эрдэнэ эрчим хүч	Дарив сумын Эрчим хүч	Тэргүүлэн ХХК /Халиун сум/	Зост өндөр ХХК /Тайшир сум/
Санал	24	13	12	14		
Батлагдсан орон тоо	25	14	12	14		
Ажилласан орон тоо	25	13	14	14	9	14

Эх сурвалж: Аудитын явцад хийгдсэн тооцоо судалгаанаас

“Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ-аас бусад үйлдвэрийн газрууд батлагдсан орон тооны хязгаарыг баримтлан ажиллаж байна.



Харьцуулалт: Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын эрхэлж буй үйл ажиллагаа, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн тоо, үйлдвэрийн газрын хүчин чадал ижил түвшний Халиун, Тайшир сумын төвлөрсөн халаалт хариуцдаг хязгаарлагдмал хариуцлагатай компаниуд 9-14 ажилтан ажиллуулсан байна.

Хувийн хэвшлийн тодорхойлон ажиллуулсан орон тооны бүтцийг орон нутгийн өмчит нэгжүүдийн бүтэцтэй харьцуулахад орон нутгийн өмчит нэгжүүдэд ээлжийн слесарийн орон тоо 1-3-аар илүү байна. Мөн орон нутгийн өмчит нэгжүүдэд нягтлан бодогч бүтэн орон тоонд ажиллаж байгаа бол хувийн хэвшил нягтлан бодогчоо гэрээгээр /өөр байгууллагын нягтлан бодогчид 40%-тай дүйцэх хэмжээний цалин өгч/ ажиллуулсан байна.

“Солонго дулааны станц” ААТҮГ нь батлагдсан орон тооны хязгаарыг баримталсан боловч доорх албан тушаалын орон тоог цөөлөх боломжтой байгааг судалж шийдвэрлэх хэрэгтэй байна.

Үндэслэл:

1. Тус үйлдвэрийн газар нь 2019 онд шинээр байгуулагдсан халаалтын зуух, халаалтын шугам сүлжээ шинэ байдал

2. Доорх орон тоонд ажилласан албан тушаалтны ажил үүргийн хуваарь, ажлын тайланд тусгасан хийж хэрэгжүүлсэн ажил ажлын цаг ашиглалт

Хүснэгт №18. Илүүц бүтэц

ҮЗҮҮЛЭЛТ	БАТЛАГДСАН ОРОН ТОО	АЖИЛЛАВАЛ ЗОХИХ ОРОН ТОО
ЗУУХНЫ СЛЕСАРЬ	4	1
ДАМЖУУЛАХ СТАНЦЫН ОПЕРАТОР	4	1
БОРЛУУЛАЛТЫН БАЙЦААГЧ	1	0

Эх сурвалж: Аудитын явцад хийсэн тооцоо судалгаа

Тайлбар: Халаалтын тогоо бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй байгаа тул зуухны слесарийн тоог цөөлөх боломжтой байна.

Дахин дамжуулах станцын оператор нь халуун усны түгээлт хариуцаж байна. 2020 онд 5.1 сая төгрөгийн халуун усны орлого төвлөрч уг орлогыг олохын тулд 18.1 сая төгрөгийн цалингийн зардал гаргасан байна. Үйлдвэрийн газар нь ашгийн төлөө бизнесийн байгууллага учир энэ байдал нь тус газрын ашиг олох үндсэн зорилгод нийцэхгүй байна.

Борлуулалтын байцаагч нь дулаан болон халуун усны тооцоог сар бүрийн 25-ны дотор хэрэглэгчид хүргэх, барагдуулах ажлыг хариуцаж байна энэ нь орон тооны нярвын ажил үүрэгт хамаарч байгаа тул уг орон тоо илүү байна.

Илрүүлэлт:

- Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын орон тооны хязгаарыг эрхэлж буй үйл ажиллагаатай уялдуулан оновчтой тогтоогоогүй байна.

- “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ батлагдсан орон тооны хязгаараас илүү ажилтан ажиллуулж 3.1 сая төгрөгийн цалин олгосон байна.



Б.1.2 Сумдын дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын ажиллагсдад батлагдсан ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь байхгүй байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, Уурын ба халаах зуухыг төхөөрөмжлөх, аюулгүй ажиллагааны дүрмийн 9.2.1⁶, “Солонго дулааны станц” ААТҮГ-ын баталсан ажлын байрны тодорхойлолтыг тус тус шалгуур болгон тулган баталгаажуулж дүгнэлт өгсөн.

Сумдын дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын ажиллагсдад батлагдсан ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь байхгүй байдлаас шалтгаалан хэн юу хийх нь тодорхой бус ажлын хуваарилалт тэгш бус байна.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удад орон тоо бүтцийг оновчтой тодорхойлж албан тушаалтны ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг нэгдсэн байдлаар гаргаж мөрдсөнөөр ажлын бүтээмж, чанар сайжирч ажлын хийдэгдэл, давхардал арилах боломж бүрдэх тул яаралтай шийдвэрлэх нь зүйтэй юм.

Илрүүлэлт:

- Сумдын дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд ажиллагсдад ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг баталж мөрдүүлээгүй байна.
- Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын машинистууд зуух ажиллуулах зөвшөөрөлгүй байна.
- “Солонго дулааны станц” ААТҮГ-ын ерөнхий инженерийн албан тушаалд ажиллаж байгаа албан тушаалтан ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжил эзэмшээгүй байна.
- “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ-ын захирал төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй байна.
- “Суурин дулаан” ААТҮГ-ын нягтлан бодогчийн албан тушаалд газрын кадастрын инженер мэргэжил эзэмшсэн хүн ажиллаж байна.

Б.2. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ААТҮГ-УДЫН ХӨРӨНГИЙН НӨӨЦИЙГ ОНОВЧТОЙ БҮРДҮҮЛСЭН ҮҮ?

Б.2.1. Улс, орон нутаг, орон нутгийн хөгжлийн сангаас дулаан үйлдвэрлэгч ААТҮГ-удад хангалттай хэмжээний хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 10,172.8 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 5.9 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 3,528.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, шугам сүлжээ түүний засвар сайжруулалт хийгдсэн байна.

Үйлдвэрийн газрууд өөрийн хөрөнгөөр 83.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 37 хувь буюу 31.0 сая төгрөг нь ажиллагсдын ая тух, албан хэрэгцээг хангах машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бэлтгэхэд зарцуулагдсан бол барилга байгууламж барихад өөрийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтын 63 хувь буюу 52.4 сая төгрөг зарцуулсан байна. Мөн “Солонго дулааны станц” ААТҮГ нь 1.8 сая төгрөгийн суурин компьютерыг ОНӨГ-аас шилжүүлэн авч, “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ нь 1.6 сая төгрөгийн тавилга эд хогшлыг хандиваар хүлээн авч бүртгэлд тусгасан байна.

⁶ “Сургалтад хамран аттестатчилагдсан бөгөөд зуух ажиллуулах эрхийн үнэмлэхтэй хүмүүст зуух ажиллуулах зөвшөөрөл олгоно”



Хүснэгт №19. Хөрөнгө оруулалт (сая.төгрөг)

ААТҮГ-ЫН НЭР/ ХО ТӨРӨЛ	УТХО	ОНТХО	ОНХС	ӨӨРИЙН ОРЛОГООС	ШИЛЖҮҮЛЭН АВСАН	ХАНДИВ
ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ	-		204.9	73.8	-	-
ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ			333.8			1.6
СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ	8,125.4	5.9	2,990.0	7.7	1.8	-
СУУРИН ДУЛААН	2,045.5			1.8		

Зураг №1. Солонго дулааны станцын барилга байгууламж



“Солонго дулааны станц” ААТҮГ нь 2019 онд шинээр байгуулагдсан ба одоогоор УТХО-аар 8,125.4 сая төгрөг, ОНТХО-аар 5.9 сая төгрөг, ОНХС-аас 2,990.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, өөрийн орлогоос 7.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж ОНӨГ-аас

1.8 сая төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч нийт 11,130.8 сая төгрөгийн хөрөнгө бүрдүүлсэн байна. УТХО-аар хийгдсэн 5,814.3 сая төгрөгийн шугам сүлжээг бүртгэлд тусгаагүйд УТХО-ын аудитаар, ОНТХО-аар хийгдсэн 5.9 сая төгрөгийн шугам сүлжээг бүртгэлд тусгаагүйд ОЭТХО-ын аудитаар тус тус шийдвэр өгчээ. Үйлдвэрийн газарт ажиллаж хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг газар дээр нь үзэхэд үндсэн хөрөнгө эзэмшигчийн карт хөтөлдөг боловч өмчлөлийн хөрөнгөө кодлоогүй байна.

Зураг №2. Суурин дулаан ААТҮГ-ын барилга



“Суурин дулаан” ААТҮГ нь 2020 онд шинээр байгуулагдсан ба УТХО-аар 2,045.5 сая төгрөг, өөрийн орлогоос 1.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж бүртгэлд тусгасан байна.



Зураг №3. Эрдэнэ эрчим хүч ОАНААТҮГ-ын гадна байдал /Зуухны барилга, нүүрсний саравч, конторын барилга/



“Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ-т 2014 оноос хойш хийгдсэн хөрөнгө оруулалтын судалгааг хийхэд ОНХС-аас 204.9 сая төгрөг, өөрийн орлогоос 73.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж бүртгэлд тусгасан байна. Өөрийн орлогоос конторын барилга 38.0 сая төгрөг, гадна блок хашаа 6.1 сая төгрөг, граж 2.0 сая төгрөг, нүүрсний саравч 2.3 сая төгрөгөөр барьж байгуулсан ба бусад тавилга хогшил, тоног төхөөрөмжид 25.3 сая төгрөг зарцуулж ажлын орчин нөхцөлөө сайжруулсан байна.

Зураг №4. “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-ын гадна зураг



Тус үйлдвэрийн газрын бүртгэл, эзэмшилд байдаг худагт аймгийн ОНХС-аас сайжруулалт хийснийг сумын ЗДТГ-т бүртгэснээр бодит 1 худгийн бүртгэл 2 газар давхар бүртгэгдсэн байна. Үйлдвэрийн газарт ажиллаж хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг газар дээр нь үзэхэд үндсэн хөрөнгө эзэмшигчийн карт хөтөлдөггүй, өмчлөлийн хөрөнгөө кодлоогүй байна.

“Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-т 2014 оноос хойш хийгдсэн хөрөнгө оруулалтын судалгааг хийхэд ОНХС-аас 333.8 сая төгрөг, хандиваар 1.8 сая төгрөгийн хөрөнгө бүрдүүлж бүртгэлд тусгасан байна. ОНХС-аас 2015-2017 онд 315.8 сая төгрөгийн санхүүжилт олгож уурын зуухны барилга халаалтын зуух шинээр баригдсан боловч одоо болтол ашиглаагүй байна. Аудитын хугацаанд ковид-19 цар тахлын тархалтаас

шалтгаалсан хөл хорио урт хугацаагаар тогтоогдсоноос тус барилга, байгууламжийн нөхцөл байдалтай газар дээр нь очиж нүд үзэж танилцаагүй ба нөхцөл байдлыг судалж оновчтой шийдэл гаргах хугацаатай шийдвэр өгч хэрэгжилтийг давтан үзэхээр үлдээсэн болно.

Илрүүлэлт:

- “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-т сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэн 2017 онд хүлээн авсан 315.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон уурын зуухны барилгыг одоо болтол ашиглаагүй байна.



- "Дарив сумын эрчим хүч" ААТҮГ-ын санхүүгийн тайланд бүртгэлтэй үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл нэр төрлөөрөө нэгж байгууллагадаа байхгүй байна. Үйлдвэрийн газрын удирдлагаас хөрөнгөд тавих хяналт сулаас үйлдвэрийн газрын хөрөнгө бодитоор байхгүй байх эрсдэлтэй байдал бий болсон байна.
- "Эрдэнэ эрчим хүч" ОНӨААТҮГ-т аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 99.0 сая төгрөгийн ухаалаг худаг ашиглалтын шаардлага хангахгүй болсон ба бодит 1 худгийг сумын Засаг даргын тамгын газар болон үйлдвэрийн газарт давхар бүртгэсэн байна.
- Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-ууд өөрийн эзэмшлийн конторын барилга, граж, агуулах гэх мэт хөрөнгөндөө үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гаргуулаагүй байна.

Б.2.2. Үндсэн хөрөнгө бараа материалыг НББОУС-ыг мөрдөж ангиллын дагуу зөв бүртгэх нэгдсэн бодлого шаардлагатай байна.

НББОУС-2, НББОУС-16-д бараа материал, үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэх ерөнхий шалгуурыг заасан байдаг. Орон нутгийн өмчит дулаан үйлдвэрлэгч ААТҮГ-уудын санхүүгийн тайланд нийт 8,204.9 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө 63.2 сая төгрөгийн өртөгтэй бараа материал бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн 65 хувь нь "Солонго дулааны станц" ААТҮГ-т, 25 хувь нь "Суурин дулаан" ААТҮГ-т, 7 хувь нь "Дарив сумын эрчим хүч" ААТҮГ-т 3 хувь нь "Эрдэнэ эрчим хүч" ОНӨААТҮГ-т тус тус бүртгэгджээ. Үндсэн хөрөнгийн бүртгэлийг тулган баталгаажуулахад "Суурин дулаан" ААТҮГ-т 0.2 сая төгрөгийн өртөгтэй 2 ширхэг бараа материалын шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

Бараа материалын 32 хувь нь "Дарив сумын эрчим хүч" ААТҮГ-т, 27 хувь нь "Солонго дулааны станц" ААТҮГ-т, 20 хувь нь "Суурин дулаан" ААТҮГ-т, 20 хувь нь "Эрдэнэ эрчим хүч" ОНӨААТҮГ-т тус тус бүртгэгдсэн байна. Бараа материалын бүртгэлийг тулган баталгаажуулахад Дарив сумын эрчим хүч ААТҮГ нь 18.9 сая төгрөгийн бичиг хэрэг, сэлбэг хэрэгсэл, нүүрсийг аж ахуйн материалд, "Солонго дулааны станц" ААТҮГ нь 0.7 сая төгрөгийн тавилга эд хогшлыг бусад хангамжийн материалд ангилал зөрүүлэн бүртгэсэн байна. Мөн "Солонго дулааны станц" ААТҮГ 2.2 сая төгрөгийн, "Суурин дулаан" ААТҮГ нь 1.0 сая төгрөгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа бараа материалыг шаардах хуудсаар зарлагдсан нь НББОУС-тай зөрчилдөж байна.

Илрүүлэлт:

- "Суурин дулаан" ААТҮГ үндсэн хөрөнгийн шинж чанар агуулаагүй 0.2 сая төгрөгийн аж ахуйн материалыг үндсэн хөрөнгөд, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөд зүйл анги зөрүүлэн бүртгэсэн
- "Солонго дулааны станц" ААТҮГ 0.7 сая төгрөгийн тавилга эд хогшлыг бусад хангамжийн материалд зүйл анги зөрүүлэн бүртгэсэн
- Үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа аж ахуйн материал, сэлбэг хэрэгслийг байгууллагын захирлын тушаал шийдвэргүйгээр данс бүртгэлээс хассан
- Акталж устгах шийдвэр гарсан 7 нэр төрлийн 8.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй

Б.2.3. Үйлдвэрлэлд ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг НББОУС-ын дагуу үнэн зөв байгуулаагүй байна.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-уудын тайлант жилийн ашиг алдагдалд шууд нөлөөлдөг санхүүгийн бус зардал бол үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал юм. НББОУС-16-д



хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацаанд системтэй хуваарилсан хуваарилалтыг хэлнэ гэж тодорхойлсон байдаг.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-дад санхүүгийн нэгдсэн бодлого байхгүйгээс хөрөнгийн элэгдлийн зардлыг харилцан адилгүй байдлаар байгуулсан байна. “Солонго дулааны станц” ААТҮГ нь санхүүгийн программ хангамж ашигладаг ба өгөгдлөө буруу оруулснаас тооцооллын алдаа үүссэн, “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ, “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ нь бүртгэлээ гараар хөтөлдгөөс тооцооллын алдаа үүссэн, “Суурин дулаан” ААТҮГ нь элэгдэл байгуулахдаа үйл ажиллагаа явуулдаг сараараа элэгдэл байгуулснаас элэгдлийн зардлыг илүү, дутуу байгуулж зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Хүснэгт №20. Элэгдлийн зардал (сая.төгрөг)

ЭЛЭГДЛИЙН ҮЙЛДВЭРИЙН НЭР	ЗАРДАЛ/ ГАЗРЫН	СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ	СУУРИН ДУЛААН	ЭРДЭНЭ ХҮЧ	ЭРЧИМ	ДАРИВ ЭРЧИМ ХҮЧ	СУМЫН
ИЛҮҮ БАЙГУУЛСАН ДҮН		2.2	0.07	15.8		9.9	
ДУТУУ БАЙГУУЛСАН ДҮН		1.6	7.9	14.9		3.2	

Илрүүлэлт:

- Тооцооллын алдаа гаргаж элэгдлийн зардлыг буруу байгуулсан

Б.2.4. Хөрөнгийн тооллогыг нэр төдий баримт бүрдүүлэх хэмжээнд хийх буруу хандлага хэвшсэн байна.

Аудитын хугацаанд “Солонго дулааны станц” ААТҮГ, “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ-уудад биечлэн очиж хөрөнгийн ашиглалт бодит нөхцөл байдалтай танилцсан. Бусад нэгжүүдийн хөрөнгийн нөхцөл байдлыг баримтын хүрээнд үзэж дүгнэсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлд эд хөрөнгийн тооллого хийх хугацааг тодорхой зааж өгсөн. Эд хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулах, хөрөнгө эзэмшигчид картлах, орон нутгийн өмчийг коджуулах ажил хангалтгүй хийгдсэн байна.

Мөн эд хариуцагч, нягтлан бодогч солигдоход хөрөнгийн тооллого зохион байгуулаагүй байлаа.

Тооллогын баримтыг тулган баталгаажуулахад “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ 10.3 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 12.2 сая төгрөгийн биет бус хөрөнгийг тооллогод хамруулаагүй барилга байгууламжийг 161.5 сая төгрөг, машин тоног төхөөрөмжийг 81.3 сая төгрөгөөр тус тус илүү, бэлэн бүтээгдэхүүнийг 14.2 сая төгрөгөөр дутуу байна гэсэн үр дүн гаргасан боловч үлдэгдлийг нягтлан бодох бүртгэлтэй тулгаж зөрүүг шийдвэрлээгүй, “Солонго дулааны станц” ААТҮГ нь 11.8 сая төгрөгийн түлш шатах тослох материалын үлдэгдлийг тооллогод хамруулаагүй баримт материал архивласан байна.

Аудитын хугацаанд дээр дурдсан 2 нэгжид үндсэн хөрөнгийн бүрэн, бараа материалын хэсэгчилсэн тооллого хийсэн.

“Солонго дулааны станц” ААТҮГ-т хийсэн тооллогоор ямар нэг зөрүү илүүдэл дутагдал илрээгүй харин “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ-т ширээ 2 ширхэг, ус шүүгч 1 ширхэг бүртгэлээс илүүдэж, нүүрс, зургийн аппарат цемент зэрэг 5,023.0 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материал дутагдсан.



Өмч хөрөнгийн байдалтай газар дээр нь нүд үзэж танилцахад орон нутгийн өмчийн хөрөнгө кодгүй эзэмшигчид картлаагүй байгаа нь хөрөнгө солигдох, эзэнгүйдэх нөхцөл бүрдсэн байна. Орон нутгийн өмчийн газраас дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын хөрөнгийг кодлох ажлыг удирдлагаар ханган зохион байгуулж өмч хөрөнгийн эзэмшлийг тодорхой болгох нь зүйтэй юм.

Илрүүлэлт:

- “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ-ын хөрөнгийн үлдэгдэлд хэсэгчилсэн тооллого хийхэд 3 нэр төрлийн 5.0 сая төгрөгийн хөрөнгө дутагдаж 2 нэр төрлийн 3 ширхэг хөрөнгө бүртгэлээс илүүдсэн

Б.3. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ААТҮГ-УУД САНХҮҮГИЙН НӨӨЦИЙГ ҮНЭН ЗӨВ БҮРТГЭЛ БАЙНА УУ?

Б.3.1 Анхан шатны баримтаас хөөн тооцоход 15.6 сая төгрөгийн борлуулалтын авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Орон нутгийн өмчит дулаан үйлдвэрлэгч ААТҮГ-уудын борлуулалтын орлогын бүрэлдэхүүнд халаалт, цэвэр ус, халуун усны үйлчилгээ үзүүлсний төлбөр багтаж байна.

Эрчим хүчний тухай хуулийн 11.3.3⁷-д заасны дагуу аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тогтоолоор баталсан дулааны эрчим хүчийг айл өрх, аж ахуйн нэгж байгууллага, төсөвт байгууллагад борлуулах үнэ тарифыг мөрдөж ажилласан байна.

Хүснэгт №21. Борлуулалтын орлогын гүйцэтгэл (сая.төгрөг)

ААТҮГ-ын нэр/он, орлого	Борлуулалтын орлого					
	2019 он		2020 он		Санхүүгийн тайланд	
	Бодит орлого	Орсон орлого	Бодит орлого	Орсон орлого	Бүртгэсэн авлагын дүн	Бүртгээгүй авлагын дүн
Эрдэнэ эрчим хүч	193.2	191.3	198.2	200.4	0	0
Дарив сумын Эрчим хүч	256.7	249.9	276.8	262.3	15.2	10.7
Солонго дулааны станц	355.6	348.2	509.4	496.2	27.8	
Суурин дулаан	-	-	232.7	226.4	1.3	4.9

Эх сурвалж: Харилцахын хуулга, байгуулсан гэрээ

“Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ: 2020 оны байдлаар 5 төсөвт байгууллагын 3 аж ахуйн нэгж байгууллага хоршоо дэлгүүрийг төвлөрсөн халаалтаар хангаж, 156 хэрэглэгчид цэвэр ус борлуулж 200.4 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлсэн байна. Борлуулалтын орлогын 99 хувийг халаалтын орлого, 1 хувийг цэвэр усны орлого бүрдүүлж байна.

⁷ “Зохицуулах зөвлөлийн баталсан аргачлал, журмын дагуу харьяалах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тариф, хэрэглэгчийн үнийг батлах, шалгах, нийтлэх”



Борлуулалтын орлогын тооцоог 2018 оноос хойш хөөн тооцоход хэрэглэгчээс нэхэмжилсэн төлбөрөө төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

“Дарив сумын эрчим хүч” ААТҮГ: 2020 оны байдлаар 6 төсөвт байгууллага, 7 аж ахуйн нэгж байгууллага хоршоо дэлгүүр, 10 айл өрхийг төвлөрсөн халаалтаар хангаж, 190 хэрэглэгчид цэвэр ус борлуулж, 120 хэрэглэгчид халуун усны үйлчилгээ үзүүлж 262.3 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлсэн байна. Борлуулалтын орлогын 99 хувийг халаалтын орлого, 1 хувийг цэвэр ус, халуун усны орлого бүрдүүлж байна. Борлуулалтын орлогын тооцоог 2018 оноос хойш хөөн тооцоход 10.7 сая төгрөгийн борлуулалтын авлагыг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

“Солонго дулааны станц” ААТҮГ: 2020 оны байдлаар 6 төсөвт байгууллага, 4 аж ахуйн нэгж байгууллага, дэлгүүр, 368 айл өрхөд халаалт, халуун ус үйлчилж 496.2 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлсэн байна. Борлуулалтын орлогын тооцоог 2019 оноос хойш хөөн тооцоход 27.8 сая төгрөгийн борлуулалтын авлагыг санхүүгийн тайланд авлагаар тусгажээ.

“Суурин дулаан” ААТҮГ: 2020 оны байдлаар 6 төсөвт байгууллага, 7 аж ахуйн нэгж байгууллага хоршоо дэлгүүр, 22 айл өрхийг төвлөрсөн халаалтаар ханган 226.5 сая төгрөгийн борлуулалтын орлого төвлөрүүлсэн байна. Борлуулалтын орлогын тооцоог байгуулсан гэрээний дагуу хөөн тооцоход 4.9 сая төгрөгийн борлуулалтын авлагыг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Илрүүлэлт:

- “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-ын борлуулалтын орлогыг хөөн шалгахад 10.7 сая төгрөгийн борлуулалтын авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.
- “Суурин дулаан” ААТҮГ нь халаалтын төлбөрөө НӨАТ-гүй үнээр нэхэмжилснээс үүссэн 4.9 сая төгрөгийн борлуулалтын авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.
- Эрдэнэ, Дарив сумдын дулаан үйлдвэрлэгч ААТҮГ-ууд сумын худаг ашиглаж орлого олж байгаа боловч холбогдох зөвшөөрөл аваагүй, батлагдаагүй үнэ тарифаар иргэдээс төлбөр авсан байна.
- “Солонго дулааны станц” ААТҮГ нь хэрэглэгч айл өрхүүдийн 76 хувьтай дулаанаар хангах гэрээ байгуулаагүй байна.
- “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ дулааны төлбөрийг төрөөс хариуцан төлөх хэрэглэгчийн мэдээллийг тулган баталгаажуулахад 2.5 сая төгрөгийн төлбөрийг илүү нэхэмжлэн авсан

Б.3.2. Бүрдүүлсэн орлогыг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулаагүй байна.

Аудитаар орон нутгийн өмчит дулаан үйлдвэрлэгч ААТҮГ-удын үйл ажиллагаандаа зарцуулсан мөнгөн хөрөнгийн 2018-2020 оны судалгааг анхан шатны баримтаас хөөн шалгаж дүгнэлт анализ хийсэн. Дээрх хугацаанд орон нутгийн өмчит дулаан үйлдвэрлэгч ААТҮГ-ууд нийт 2,729.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Зарцуулалтын 19 хувь болох 508.1 сая төгрөгийг 2018 онд 37 хувь болох 1,013.5 сая төгрөгийг 2019 онд 44 хувь болох 1,207.4 сая төгрөгийг 2020 онд хүснэгт №22-т дурдсан нэгжүүд зарцуулжээ.

Хүснэгт №22. Зарцуулалт (сая.төгрөг)

ААТҮГ-ын нэр/он	2018 ОН	2019 ОН	2020 ОН	ДҮН
ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ	201.8	200.7	170.1	572.6
ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ	306.3	315.1	320.4	941.8
СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ		497.7	501.9	999.6
СУУРИН ДУЛААН			215.0	215.0
ДҮН	508.1	1,013.5	1,207.4	2,729.0



“Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ: Аудит хамрах хугацаанд нийт 572.6 сая төгрөгийн зарцуулалт хийсэн байна. Жилийн нийт зарцуулалтын 42 хувийг цалинд, 21 хувийг нүүрс худалдан авахад 14 хувийг бараа материал үндсэн хөрөнгө худалдан авахад 7 хувийг шатахууны зардалд 7 хувийг цахилгааны зардалд үлдсэн 8 хувийг бусад зардалд зарцуулжээ.

Тус үйлдвэрийн газрын жилийн дундаж зарцуулалт 190.8 сая төгрөг байгаагийн 26 хувь буюу 49.8 сая төгрөг нь сул зардал байна.

Хүснэгт №23. Сул зардал (сая,төгрөг)

СУЛ ЗАРДЛЫН БҮРЭЛДЭХҮҮН / ОН	2018 ОН	2019 ОН	2020 ОН
ОРОН ТОО ИЛҮҮ АЖИЛЛУУЛСАН	2.3	-	0.8
ХАНДИВ ТУСЛАМЖ АКТЫН ТӨЛБӨРТ	2.9	2.3	0.5
УДИРДЛАГА ТҮҮНИЙ ХАМААРАЛ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН НЭРИЙН ДАНСААР ГАРСАН	9.9	50.3	38.7
ЭД ХАРИУЦАГЧИЙН ТАЙЛАНД БҮРТГЭЭГҮЙ МАТЕРИАЛД	23.5	4.6	13.4
ДҮН	38.6	57.2	53.4

“Дарив сумын эрчим хүч” ААТҮГ: Аудит хамрах хугацаанд нийт 941.6 сая төгрөгийн зарцуулалт хийсэн байна. Жилийн дундаж зарцуулалт 313.9 сая төгрөг байгаа судалгааны дүн гарлаа. Тус үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагаа хангалтгүйгээс харилцахаар 2018-2020 онд зарцуулсан нийт 206.9 сая төгрөгийн зарцуулалт анхан шатны нотлох баримтаар дэмжигдэхгүй байгууллагын үйл ажиллагаанд зарцуулагдсан эсэх нь тодорхой бус байна. Тухайлбал:

- ✓ 2018-2020 онд анхан шатны баримтын бүрдэлгүйгээр 12.9 сая төгрөгийн зарлага гарсан
- ✓ 2018-2020 онуудад хувь хүнээс авсан зээлийн тооцоог давтан тооцоход 6 иргэнээс авсан 41.3 сая төгрөгийн зээлийг харилцах дансаар дамжуулаагүй
- ✓ 2020 онд харилцах данснаас 50.6 сая төгрөг нүүрс, тээврийн хөлс нэрээр гарсан, 28.7 сая төгрөг шатахуун нэрээр гарсан боловч эд хариуцагчийн нэр төрлийн тайлан гаргаагүй
- ✓ 2020 оны 9, 10 дугаар сарын цалингийн цэс харилцах дансны хуулгаар гарсан цалингийн зарлагаас 8.4 сая төгрөгөөр зөрүүтэй
- ✓ 2020 онд 2 иргэнд 0.9 сая төгрөгийг зээлийн хүүд төлсөн гэх боловч зээлийн төлбөрийн нөхцөл тохирсон гэрээ байхгүй
- ✓ Санхүүгийн тайланд тусгагдсан 2.6 сая төгрөгийн авлага, 25.0 сая төгрөгийн нүүрсний өглөг үүссэн анхан шатны баримт материал байхгүй
- ✓ 2018-2020 онуудад байгууллагын харилцах данснаас захирлын хувийн харилцах дансанд 0.5 сая төгрөг, нягтлан бодогчийн хувийн харилцах дансанд 7.7 сая төгрөг ажиллагсдын хувийн харилцах дансанд 5.0 сая төгрөг, нярвын хувийн харилцах дансанд 23.4 сая төгрөгийн зарлага гарсан боловч тус хөрөнгийг юунд зарсан нь тодорхой бус байна.

“Солонго дулааны станц” ААТҮГ: Аудит хамрах хугацаанд нийт 999.6 сая төгрөгийн зарцуулалт хийсэн байна. Жилийн нийт зарцуулалтын 28 хувийг цалинд, 30 хувийг нүүрс худалдан авахад 17 хувийг бараа материал үндсэн хөрөнгө худалдан авахад 1 хувийг шатахууны зардалд 11 хувийг цахилгааны зардалд, 4 хувийг зээлийн төлбөрт үлдсэн 9 хувийг бусад зардалд зарцуулжээ. Тоон үзүүлэлтээс харахад зарцуулалт нэмэгдсэн байгаа нь үйл ажиллагаа өргөжиж байгаатай холбоотой байна.



“Суурин дулаан” ААТҮГ: Тус үйлдвэрийн газар нь 2020 онд байгуулагдсан ба нийт 215.0 сая төгрөгийн зарцуулалт хийсэн байна. Зарцуулалтын 34 хувийг цалинд, 50 хувийг нүүрс худалдан авахад 5 хувийг бараа материал үндсэн хөрөнгө худалдан авахад 8 хувийг цахилгааны зардалд үлдсэн 3 хувийг шатахуун, татвар, төлбөр хураамж тэтгэмж хандив бусад зардалд зарцуулжээ. Санхүүгийн тайлангийн аудитаар олгосон хандивт төлбөр тогтоосон байна.

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчтэй хийсэн худалдан авалтын талаар:


Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-ууд нь харилцагч, хэрэглэгчдээсээ НӨАТ орсон дүнгээр үзүүлсэн үйлчилгээний төлбөрөө нэхэмжлэн авч НӨАТ-ын өглөгийг улсад төлөх, үүнээс үйл ажиллагаа явуулахтай холбоотой НӨАТ төлөгчтэй хийсэн худалдан авалтын НӨАТ-ын авлагаа тооцож зөрүү дүнгээр НӨАТ төлөгч нэгжүүд юм. Өөрөөр хэлбэл боломжит бүх худалдан авалтаа НӨАТ төлөгчтэй хийснээр үйл ажиллагааны үр дүн буюу ашигт ажиллагаанд шууд үр дүн бий болгох боломжтой гэсэн үг.

Аудитаар 2020 оны санхүүгийн тоон үзүүлэлтэд тулгуурлан НӨАТ төлөгчтэй хийж болох боломжит мөнгөн хөрөнгийн хэмжээг гарган дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын 2020 онд гүйцэтгэлээр гарсан НӨАТ-тай худалдан авалттай харьцуулсан хувийг дүрсээр харууллаа. “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-ын НӨАТ-тай худалдан авалт муу түвшинд буюу хийж болох боломжит НӨАТ-тай худалдан авалтын дүнгийн 13 хувьд хүрсэн гүйцэтгэлтэй, “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ, “Суурин дулаан” ААТҮГ-ын тухайд НӨАТ-тай худалдан авалт дундаж түвшинд буюу хийж болох боломжит НӨАТ-тай худалдан авалтын дүнгийн 42-47 хувьд хүрсэн гүйцэтгэлтэй, “Солонго дулааны станц” ААТҮГ НӨАТ-тай худалдан авалт сайн түвшинд буюу хийж болох боломжит НӨАТ-тай худалдан авалтын дүнгийн 72 хувьд хүрсэн гүйцэтгэлтэй байна.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-ууд цалин, татвар, төлбөр хураамж, тэтгэмжээс бусад гүйлгээг НӨАТ төлөгчтэй хийхийг эрмэлзвэл НӨАТ төлөх дүн буурч ашиг нэмэгдэх боломжтой юм.

Дүрслэл №4. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчтэй хийсэн худалдан авалтын хувь

Солонго дулааны станц" ААТҮГ "Эрдэнэ эрчим хүч" ОНӨААТҮГ "Суурин дулаан" ААТҮГ "Дарив сумын эрчим хүч" ААТҮГ



Илрүүлэлт:

- “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-ын харилцахаар 2018-2020 онд зарцуулсан нийт 206.9 сая төгрөгийн зарцуулалт анхан шатны нотлох баримтаар дэмжигдэхгүй байна.
- "Дарив сумын эрчим хүч" ААТҮГ нь иргэн Д.Тэмүүлэнд 1.2 сая төгрөгийн зээлийн төлбөрийг илүү олгосон боловч авлагаар тусгаагүй
- "Дарив сумын эрчим хүч" ААТҮГ ажиллагсдад 2.6 сая төгрөгийн цалин илүү олгосон
- "Эрдэнэ эрчим хүч" ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч 0.4 сая төгрөгийн цалингийн урьдчилгааг шууд бичилтээр хаасан байна.



- “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ нь 25.3 сая төгрөгийн байгууллагад төлөх өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй
- “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ нь аудит хамрах хугацаанд 41.5 сая төгрөгийн хангамжийн материал, урсгал засварын материалыг эд хариуцагчийн тайланд орлого авалгүйгээр шууд зарцуулсан
- “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ 5.8 сая төгрөгийг хандив, тусламж акт төлөхөд зарцуулсан
- “Эрдэнэ сумын эрчим хүч” ОНӨААТҮГ-т аудит хамрах хугацаанд байгууллагын захирлын хувийн харилцах дансаар дамжуулан 1.3 сая төгрөг, нягтлан бодогчийн хувийн харилцах дансаар дамжуулан 3.3 сая төгрөг, нягтлан бодогчийн хамаарал бүхий этгээдийн хувийн харилцах дансаар дамжуулан 94.1 сая төгрөгийн нийт 98.8 сая төгрөгийн бараа материал бэлтгэсэн
- Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-ууд нэмэгдсэн өртгийн албан татварын тайлангийн борлуулалтын орлого, худалдан авалтыг үнэн зөв тайлагнаагүйгээс үүссэн 76.9 сая өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй

Б.3.3 Нүүрс худалдан авахдаа худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2⁸, 8.4⁹, 8.5¹⁰, 8.7.1¹¹ болон Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол, 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус баримтлан ажиллахаар хуульчилсан.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын жилийн нүүрсний худалдан авалт босго үнээс давсан буюу худалдан авах ажиллагаа зохион байгуулж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар байна.

Гэвч үйлдвэрийн газрууд 2018-2019 онд бүгд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй, 2020 онд “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ, “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-ууд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийжээ.

“Солонго дулааны станц” ААТҮГ нь 2020 нүүрс худалдан авах худалдан авах ажиллагаа зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ байгуулсан боловч тендерт шалгарсан оролцогчоос өөр бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авалт хийсэн байна.

Харин “Суурин дулаан” ААТҮГ нь 2020 оны 11 сард нүүрс нийлүүлэх худалдан авах ажиллагаа зарлаж 2020 оны 12 дугаар сараас шалгарсан гүйцэтгэгчээс худалдан авалт хийж байна.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын үйлдвэрлэлийн гол нэрийн материал болох нүүрсний худалдан авалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулж шалгарсан бэлтгэн

⁸ "Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ"

⁹ "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно"

¹⁰ "Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно"

¹¹ "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох"



нийлүүлэгчээс худалдан авалт хийх процесст тавих хяналтыг тогтмол болгох шаардлагатай байна.

Хүснэгт № 24. Нүүрсний худалдан авалт(сая.төгрөг)

ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН НЭР / ОН ҮЗҮҮЛЭЛТ	2018 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН	НИЙТ ДҮН	ШХА ДҮН
ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ	25.0	34.5	47.6	24.6	131.6	131.7
ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ	41.6	48.3	45.0	33.9	168.8	168.8
СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ		134.4	166.7	125.5	426.6	237.4
СУУРИН ДУЛААН			108.2	47.0	155.2	79.3

Эх сурвалж: Аудитын явцад хийгдсэн тооцоо судалгаанаас

Илрүүлэлт:

- Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-ууд нүүрсний худалдан авалт хийхдээ худалдан авах ажиллагаа зохион байгуулалгүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

В.1 Байгууллагын дотоод хяналт үр дүнтэй байна уу?

В.1.1.Үйлдвэрийн газруудын удирдлагын үе шатны хяналт үр нөлөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа бүхэлдээ хяналтгүй байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2019 оны 7 дугаар сарын 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт 19-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралт "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм"-д заасны дагуу дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын дотоод хяналт шалгалтын нэгжийн үйл ажиллагааг дүгнэлээ.

“Солонго дулааны станц” ААТҮГ-аас бусад үйлдвэрийн газар дотоод хяналтын үйл ажиллагаа явуулах нэгж байгуулаагүй байна.

“Солонго дулааны станц” ААТҮГ нь дотоод хяналтын үйл ажиллагаа явуулах нэгжийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна. Гэвч дотоод хяналтын нэгж үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд ямар нэгэн хяналт шалгалт хийгээгүй байна.

"Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм"-ийн 10.1.3¹²-т заасны дагуу үйлдвэрийн газрын дотоод хяналтыг захирал хэрэгжүүлэхээр байгаа боловч аудитаар материаллаг хэмжээний санхүүгийн зөрчил илэрч байгаа нь удирдлагын үе шатны хяналт хангалтгүй байгааг илтгэж байна.

В.2. Аймаг орон нутгийн захиргаа болон бусад хяналт шалгалтын байгууллагаас хяналт тавьж ажилласан уу?

В.2.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлсэн хяналт үр нөлөөгүй, эрсдэлтэй асуудлыг хөндөөгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх дотоод хяналт аудитын албанаас 2018 онд “Эрдэнэ эрчим хүч” ОНӨААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд, 2019 онд “Дарив сумын

¹² “Дотоод хяналтыг гүйцэтгэх захирал хариуцна”



эрчим хүч” ААТҮГ-ын шилэн данс хөтлөлтөд, 2020 онд “Солонго дулааны станц” ААТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийжээ. Дотоод хяналт аудитын албанаас хийгдсэн хяналт шалгалтаар 0.3-0.8 сая төгрөгийн зөрчил илэрч хэрэгжилт тооцсон байна.

Дотоод хяналт аудитын алба нь Төрийн аудитын байгууллагын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг шалгалтын тайландаа нэг бүрчлэн дурддаг боловч түүний хэрэгжилтийг хангах тодорхой заавар зөвлөгөө, арга хэмжээ аваагүй байна.

"Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын үлгэрчилсэн дүрэм"-ийн 10.1.2¹³, захиралтай байгуулсан гэрээний 4.1¹⁴-д заасанчлан ОНӨГ нь дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-ын өмч хөрөнгийг эзэмшил ашиглалтад хяналт тавих зохицуулалтай боловч үр дүнтэй хяналт шалгалт хийгээгүй байна.

Гүйцэтгэлийн аудит маань дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удын 2018-2020 оны үйл ажиллагааг хамарсан бөгөөд илэрсэн зөрчлөөс дүгнэхэд төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэгч нэгжүүд дулаан үйлдвэрлэгч ААТҮГ-удад үр дүнтэй хяналт шалгалт хийгээгүй байна.

В.2.2 Санхүүгийн тайлангийн аудитаар дулаан үйлдвэрлэгчдийн санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй хяналт хийсэн боловч зөрчил гаргасан нэгж гаргасан алдаандаа дүгнэлт хийж засаж сайжруулах талаар санаачилга гаргаагүй байна.

Аудитын хамрах хугацаанд Мэргэжлийн хяналтын байгууллагаас “Солонго дулааны станц” ААТҮГ-ын үйл ажиллагаа, “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-ын шинээр ашиглалтад орсон боловч ашиглагдаагүй байгаа уурын зуухны барилга байгууламжид дүгнэлт гаргасан байна.

“Солонго дулааны станц” ААТҮГ-ын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан байдлыг давтан үзэж хэрэгжилтийг 82 хувьтай байна гэж үнэлсэн байна. “Дарив сумын эрчим хүч” ААТҮГ-ын шинээр ашиглалтад орсон боловч одоо болтол ашиглагдаагүй байгаа уурын зуухны шинэ барилга байгууламжид дүгнэлт гаргуулах хүсэлтийн дагуу үзлэг шалгалт хийж дүгнэлт гаргаж хугацаатай үүрэг өгсөн байна. Илэрсэн зөрчлийг арилгах, дутуу зүйлсийг нэмж хийлгэх, шаардлага хангахгүй зүйлсийг засварлуулах ажил зохион байгуулаагүйгээс хөрөнгө оруулалтын ажил одоо болтол үр өгөөжөө өгөөгүйгээр барахгүй үхмэл байдалд шилжсэн байна.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удад манай байгууллагын зүгээс жил бүр санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудит хийдэг. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт № 25. Илэрсэн зөрчлийн хураангуй (сая.төгрөг)

¹³ “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хамгаалалтад Орон нутгийн өмчийн газар хяналт тавьж ажиллана”

¹⁴ “...Орон нутгийн өмчийн газар хяналтын чиг үүргийг хэрэгжүүлнэ...”



ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН ТӨРӨЛ	ЭРДЭНЭ ЭРЧИМ ХҮЧ ОНӨААТҮГ					ДАРИВ СУМЫН ЭРЧИМ ХҮЧ ААТҮГ					СОЛОНГО ДУЛААНЫ СТАНЦ ААТҮГ		СҮҮРИН ДУЛААН ААТҮГ	ДҮН
	ӨМНӨХ	2018 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН	ӨМНӨХ	2018 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН	2020 ОН	2021 ОН	2021 ОН	
АВЛАГЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ								3.8		8.9				12.7
АЖЛЫН ХӨЛС ИЛҮҮ ОЛГОСОН						0.1								0.1
АЛБАН ТОМИЛОЛТЫН МӨНГӨ ИЛҮҮ ОЛГОСОН								0.5	0.3					0.8
АЛДАГДАЛ								24.9			92.9	78.3		196.1
АРВИЛАН ХЭМНЭЛТТЭЙ ХОЛБООТОЙ	3.4			0.3		0.6	0.2		0.2	0.4	201.8	0.4	1	208.3
ЗАЛРУУЛГА		7.9	3.5					5.8	16.5		1,124.90	7.5	6.6	1,172.70
И БАРИМТГҮЙ ХУДАЛДАН АВАЛТ											251.7			251.7
НҮҮРС БӨӨН ДҮНГЭЭР ШААРДАХААР ЗАРЛАГАДСАН												81.5		81.5
НЯГТЛАН БОДОГЧИЙН УР ЧАДВАРТАЙ ХОЛБООТОЙ					8.3	5.4	144.5	147.9	56.7	80.3	495.7		6.3	945.1
ӨГЛӨГИЙН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ			0.4	29.9				57.1	40.7	46			6.3	180.4
ПРОГРАММ ХАНГАМЖ														-
ТАТВАРЫН ТООЦООТОЙ ХОЛБООТОЙ		0.3	0.1		69.1	0.4	4	3	26.2		22	1.5	66.3	192.9
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ		-	-	5.3	91.8			19	-	16.6	69.5		-	202.2
ЦАЛИН ХӨЛСТЭЙ ХОЛБООТОЙ		0.9	0.4	0.8	6.6	1.2	0.1	4.4	5.3	3	11.5	0.8		35
ДҮН	3.4	9.1	4.4	36.3	175.8	7.7	148.8	266.4	145.9	155.2	2,270.0	182.6	73.9	3,479.5

Эх сурвалж: Өмнөх аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг хураангуйлан хүснэгтээр харууллаа. хамгийн өндөр дүнтэй 25 алдаа зөрчлийг тодруулан харууллаа.

Өмнөх онуудад хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитын шийдвэрээс “Дарив сумын эрчим” хүч ААТҮГ-ын доорх 19.9 сая төгрөгийн зөрчилд тогтоосон төлбөрийн акт, 123.8 сая төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага хэрэгжээгүй байна.

Хүснэгт №26. Өмнөх шийдвэрийн үлдэгдэл (сая.төгрөг)

ШИЙДВЭРИЙН ТӨРӨЛ	САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ				
	2015 ОН	2016 ОН	2019 ОН	2020 ОН	ДҮН
ТӨЛБӨРИЙН АКТ	5.5	2.2	6.6	5.6	19.9
АЛБАН ШААРДЛАГА				123.8	123.8

В.2.3 Илэрсэн зөрчлийг таслан зогсоох, цаашид давтан гаргахгүй байх талаар үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Дулаан үйлдвэрлэгч орон нутгийн өмчит ААТҮГ-удад өмнөх онуудад хийгдсэн аудитаар илэрч шийдвэр өгч хэрэгжилт хангагдсан талаар биелэлт ирүүлсэн зөрчлүүд тухайн нэгждээ хэрэгжээгүй буюу зөрчил давтагдан гарсаар байна. Энэ нь үйлдвэрийн газрын удирдлага нягтлан бодогчид үйл ажиллагааны алдаа дутагдлаа засаж залруулах сонирхолгүй, ажлын хариуцлагагүй, албан ажилд хандах зарчимч байдал дутагдалтай байгааг илтгэж байна. Илэрсэн алдаа зөрчил давтагдан гарах явдлыг таслан зогсоохын тулд захиралтай байгуулсан гэрээнд энэ талаар хариуцлагын заалт нэмж оруулж биелэлт тооцож ажиллах хэрэгтэй.



Гүйцэтгэлийн аудитаар бодлогын хэмжээнд шийдэл гаргахад үйлдвэрийн газруудын үйл ажиллагаанд эерэг нөлөөлөл бий болох, мөн үйлдвэрийн газрын эрх мэдэл, чадавхаас давсан асуудлыг шийдвэрлэхийг дээд шатны удирдлагад даалгалаа.

Аудитын тайланд хөндөгдсөн асуудал, шийдэл дүгнэлтэд ач холбогдолтой хандан өгсөн шийдвэрийг хэрэгжүүлснээр дулаан үйлдвэрлэгчдийн санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцаа хангагдаж хариуцлагад тулгуурласан орон нутгийн орлогод дэмжлэг үзүүлэхүйц үйлдвэрийн газрууд бий болох боломжтой байгаа баталгааг олгож байна.

**ДУЛААН ҮЙЛДВЭРЛЭГЧ ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРУУДАД ҮР ДҮНТЭЙ ХЯНАЛТ ТАВЬЖ, УДИРДЛАГЫН САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ
САЙЖРУУЛСНААР АШИГТАЙ АЖИЛЛАХ БҮРЭН БОЛОМЖТОЙ БАЙНА.**



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭ᠎ᠠ

МОНГОЛ УЛС ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

82093 Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Жинст баг
Утас: 7048-4004, Факс: 7048-3360

2021.06.29 № 1/500

танай 2021.06.28 ны № 323 -т

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Орон нутгийн өмчит дулааны станцуудын үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд санал байхгүй болно.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллана.



О.АМГАЛАНБААТАР

0205000633